



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар A/233

Сүхбаатар сум

Цол олгох тухай

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7, 13 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол түмний Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 88 жил, Атар газар эзэмшсний 60 жилийн ойн баярын Үндэсний бөхийн барилдаанд тав давсан Сэлэнгэ аймгийн Ерөө сумын харьяат Одсүрэн овогтой Болд-Эрдэнэ, Жавхланта сумын харьяат Бат-Очир овогтой Одбаяр, Баянгол сумын харьяат Батдорж овогтой Батжаргал нарт начин цол олгосугай

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019. оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/234

Сүхбаатар сум

Цол олгох тухай

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7, 13 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол түмний Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 88 жил, Атар газар эзэмшсний 60 жилийн ойн баярын Үндэсний бөхийн барилдаанд зургаа давсан Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын харьяат Даваадорж овогтой Баясгалан, Хүдэр сумын харьяат Эрдэнэ овогтой Хүдэрсайхан нарт харцага цол олгосугай

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/235

Сүхбаатар сум

Харваачдад цол олгох тухай

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтын үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 98 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 88 жил, Атар газар эзэмшсний 60 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Урианхай сурын харваанд түрүүлсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын харьяат Хангарьд спорт хорооны харваач Эрдэнэбатын Ганчулуунд Урианхай сурын аймгийн мэргэн, Буриад сурын эрэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын харьяат Хангарьд спорт хорооны харваач Эрдэнэбатын Ганчулуунд, эмэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Дорнод аймгийн Дашбалбар сумын харьяат Хэрлэн барс клубын харваач Батсүхийн Ганчимэг нарт Буриад сурын аймгийн мэргэн цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/236

Сүхбаатар сум

Харваачдад цол олгох тухай

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтын үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 98 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 88 жил, Атар газар эзэмшсний 60 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Үндэсний сурын харваанд түрүүлсэн Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын харьяат Хэрлэн барс клубын харваач Энхбаатарын Батсүх эмэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Дорнод аймгийн Дашбалбар сумын харьяат Хэрлэн барс клубын харваач Батсүхийн Ганчимэг нарт аймгийн мэргэн, Үндэсний сурын хүүхдийн харваанд түрүүлсэн Сэлэнгэ аймгийн Шаамар сумын харьяат Алтангэрэлийн Түвшинсанаа, Баянгол сумын харьяат Батнасангийн Ариунсанаа нарт аймгийн өсөх идэр мэргэн цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ